БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН

МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

2016.. оны 09 дугаар сарын 26.. өдөр

Дугаар 1571/2019

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: .....

Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт:	Дундговь аймгийн Цагаандэлгэр сум "240 суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөв **Шифр: ӨИ-19-19**
Хүчин чадал:	**Барилгын хэмжээ:** Тэнхлэгээрээ 27.0 м х 27.0 м хэмжээтэй, **Давхарын тоо:** ± 0.00 түвшнээс доош зоорийн давхаргүй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар **Барилгын ажлын талбай:** S= 1609.2 м^2
Захиалагч:	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг дарга
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	"Өлзий-Иш" ХХК
Регистрийн дугаар:	РД: 2890836
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2023.09.11
Ажлын төрөл:	1.2.2, 1.2.4, 1.2.5, 1.2.6, 1.3.2, 1.3.3, 1.5.1 заалтын дагуу
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдөр баталсан Б/04 тоот захирамж, Газар эзэмших эрхийн 000005590 дугаартай гэрчилгээ
Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг дарга болон "Өлзий-Иш" ХХК-ийн захирал нарын хооронд 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан ЗТ-35/19 дугаартай гэрээ
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Дундговь аймгийн Ерөнхий архитекторын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр баталсан 24/2019 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр баталсан 03/2019 дугаартай зураг төсөл боловсруулах даалгавар

Зөвшөөрөлцсөн байгууллагууд:

Дундговь аймгийн Ерөнхий архитектор	Д.Нэргүй
Дундговь аймгийн ГХБХБГазрын дарга	Э.Чагнаадорж
Дундговь аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн	М.Адъяабаатар
Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга	Ш.Төрбат

Техникийн нөхцөл олгогдсон байдал:

Техникийн нөхцөлүүд:	Олгосон байгууллага:	Дугаар, огноо:	Хүчинтэй байх хугацаа:
Дулаан хангамж:	"Ган-Илч" ХХК	2019.03.29 № В/10	2 жил

Ус хангамж, ариутгах татуурга:	Цагаандэлгэр сумын Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01/194 тоот албан бичиг		
Цахилгаан хангамж:	"БЗӨБЦТС" ТӨХК Говьсүмбэр салбар	2019.04.08 № 03/19	1 жил
Холбоо дохиолол:	"МХС" ХХК Дундговь аймгийн салбар	2019.04.17 № ТН-А002/2019	1 жил

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн:

Зураг төслийн иж бүрдэл:	Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Магадлал хийсэн экспертийн нэр:
Барилга бүтээц:	"Өлзий-Иш" ХХК	Н.Эрдэнэсүрэн
Төсөвт өртөг:	"Өлзий-Иш" ХХК Д.Ганчимэг /Тэргүүлэх төсөвчин/	Л.Оюун
Инженер геологи:	"Жонгт-Уул" ХХК /Архив № 1944/	Дүгнэлт баталгаажсан

Нэгтгэсэн дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/

Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;	**Барилга, байгууламжийн төлөвлөлт:** Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутаг дэвсгэрт баригдах "240 суудалтай соёлын төвийн барилга" нь "Барилгын хөгжлийн төв"-ийн 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 333/2014 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан "240 суудалтай соёлын төвийн барилга"-ын нэг маягийн зураг төслийг давтан ашиглаж холбохоор зураг төслийг боловсруулсан байна. **Барилга, байгууламж баригдах газрын байгаль, цаг уурын ерөнхий өгөгдөл:** Гадна агаарын хэм: - 31.2 °С Цасны ачаалал: 50 кг/м^2 Салхины ачаалал: 37 кг/м^2 Газар хөдлөлийн балл: 7 **Барилгын суурь суух буурь хөрс:** Суурь суух буурь хөрс нь бор шаргал өнгөтэй, делювий-пролювийн гаралтай, дээд-орчин үеийн дөрөвдөгчийн настай, хатуу консистенцитэй, шавранцараар чигжигдсэн хайр, хайрган хөрс, хөрсний ус илрээгүй гэж тодорхойлсон байна. **Буурь хөрсний механик шинж чанарын үзүүлэлт:** Зууралтын хүч: Сн=19.0 кПа Дотоод үрэлтийн өнцөг: Фн=43° Хэв гажилтын модуль: Ен=46 мПа Тооцооны эсэргүүцэл: Ro=450 кПа Газар шорооны ажлын зэрэг: III Хөрсний цахилгаан эсэргүүцэл: 180 Ом.м Хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн -3.47 м Хөрсний овойлтын зэрэг: Сулавтар овойлттой. **Барилга, байгууламжийн төлөвлөлт:** Барилга нь тэнхлэгээрээ 27.0 м х 27.0 м хэмжээтэй, ± 0.00 түвшнээс доош зоорийн давхаргүй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар арагт бүтээц байхаар төлөвлөсөн байна. Барилгын гадна тохижилтод явган зам талбай, авто зогсоол, ногоон суулгамал төлөвлөсөн байна. Гадна довжооны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах

	орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД/31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн байна. **1-р давхарт:** Гонх, фойе-вестибюль, хонгил, шатны хонгил, өлгүүр, заал, тайз, музей, музейн фонд, ажлын өрөө, агуулах, хувцас солих өрөө, бэлтгэлийн өрөө, техникийн өрөө, ариун цэврийн өрөөг, **2-р давхарт:** Фойе-бүжгийн зориулалттай, шатны хонгил, уншлагын танхим, ном олгох өрөө, ном хадгалах өрөө, сургалтын өрөө, кино проекцын өрөө, гэрэлтүүлгийн өрөөг тус тус төлөвлөсөн байна. **Үндсэн бүтээц нь:** **Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай, **Даацын үндсэн бүтээц:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй, **Гадна хана:** 360 мм зузаан хөнгөн блокон ханатай, 100 мм зузаан эрдэс хөвөн дулаалгатай, 120 мм зузаан тоосгон өнгөлгөөтэй, **Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай, **Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөсөн байна. **Халаалт, агаар сэлгэлт:** Халаалтын систем нь доороос түгээлттэй мухардмал эргэлттэй систем ба агаар сэлгэлтийн ердийн болон механик систем байхаар төлөвлөсөн байна. **Хашлага хийцийн дулаан дамжуулалтын коэффициент:** $К_{гх}$=0.25 Вт/м^2 °С, $К_{ху}$=0.21 Вт/м^2°С, $К_ц$=8.0 Вт/м^2 °С, $К_{гад\ хаал}$=1.82 Вт/м^2 °С Дулаан зөөгчийн температур 85°С /65°С. **Дулааны нийт ачаалал:** $Q_{бүгд}$=89050 Вт **Цэвэр бохир ус:** Барилга доторх ус хангамжийг ахуйн болон галын ус хангамжийн системтэй байхаар төлөвлөж, барилгаас гарах бохир усыг өөрийн урсгалаар зайлуулахаар төлөвлөсөн байна. **Цэвэр, бохир усны тооцоо:** $q_{бүгд}$=2.40 м^3/хон, $q_{хүй}$=1.68 м^3/хон, $q_{хал}$=0.72 м^3/хон, $q_{бох}$=2.40 м^3/хон **Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг:** Тус барилга нь цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны I ба II зэрэгт хамрагдах ба тэжээлийг гүн газардуулсан нейтральтай бие биеэ нөөцлөх хос кабель шугамаар тэжээхээр төлөвлөж, газардуулга, аянга хамгаалалтыг төлөвлөсөн байна. Сүлжээний хүчдэл 380/220В байна. Газардуулгын эсэргүүцэл 4 Ом-с хэтрэхгүй байна. **Цахилгааны ачаалал:** Оролт-1: $Р_{т1}$ = 40.0 кВт, $Р_{с1}$ = 50.0 кВт, I= 73.0 А Оролт-2: $Р_{т2}$ = 56.0 кВт, $Р_{с2}$ = 81.0 кВт, I= 102.0 А **Дотор холбоо, дохиолол:** Барилгын холбоо дохиоллын системд суурин телефон, галын дохиолол, хяналтын камерын систем, компьютерийн сүлжээ, кабелийн телевиз, зарлан мэдээлэх систем төлөвлөсөн байна.
Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт,	**Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал:** Эксперт нь ажлын зураг төслийг холбогдох норм ба

өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх;	дүрмийн шаардлагыг хангасан гэж дүгнэжээ.
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	**Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "240 хүний суудалтай соёлын төвийн барилга" баригдсанаар тухайн аймгийн иргэд урлаг соёлын үйлчилгээг стандартын шаардлага хангасан орчинд авах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдэх юм.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сум "240 суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын нэгж өртгийн задаргаа

Барилгын үндсэн хийц		Төсөвт өртөг /төг/	Барилгын талбай м2	Нэгж өртөг /төг/
1	**а/. Барилга угсралтын ажил**			
ББ,БА	Барилга нь 2 давхар, тэнхлэгээрээ 27 м х 27 м төмөр бетон баганан суурьтай, төмөр бетон арагт, төмөр бетон хучилттай барилга. Гадна хана 120 мм тоосгон өнгөлгөөтэй, 150 мм эрдэс хөвөн дулаалгатай, 360 мм блокон ханатай. Дотор хана 250 мм, 120 мм тоосгон хамар хана, хавтгай дээвэртэй.	1,046,477,405	1,086.00	963,607
ХАС		56,325,476	1,086.00	51,865
ЦБУ		26,504,850	1,086.00	24,406
ХТ-ДГ		95,026,326	1,086.00	87,501
ХД		26,280,976	1,086.00	24,200
Хэсгийн дүн		**1,250,615,033**	-	**1,151,579**
2	**б/. Зураг төслийн үнэ**			
ЗТҮ	Зураг төслийн үнэ	39,000,000	-	-
Хэсгийн дүн		**39,000,000**	-	-
Төсөвт өртгийн нэгдсэн товчоо				
БУ	Барилга угсралт	1,250,615,033	-	-
ЗТҮ	Зураг төслийн үнэ	39,000,000	-	-
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:		**1,289,615,033**		

Төсөвт өртөг:	Дундговь аймгийн Цагаандэлгэр сум "240 суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын нийт төсөвт өртгийг **1 289 615 033** /Нэг тэрбум хоёр зуун наян есөн сая зургаан зуун арван таван мянга гучин гурав/ төгрөгөөр хянасан байна.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиох хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Барилгын зураг төслийг Дундговь аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 25/09 дугаартай дүгнэлтээр, Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 13-03-025/110 дугаартай дүгнэлтээр тус тус хянагдсан байна.

Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулан, мэргэжлийн байгууллагуудтай зөвшөөрөлцөн, магадлал хийлгэж баталгаажуулах шаардлагатай.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сум "240 суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/, Дундговь аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 38 тоот албан бичгийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Магадлалын нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн хавсралт **3** хуудас дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ	Б.ГАНБОЛД
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА	Э.ХАНГАЛ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН	Б.МӨНГӨНЗУЛ

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР
240 суудалтай соёлын төв

2019 оны 09 сарын 16 өдөр

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	Зурагт SD390 ангийн монгол арматур тусгасан мөртөө ерөнхий тайлбарт AIII гэсэн мөн стандартын шинэчлэлээр А400, А240 гэж бичдэг болоод удаж байгааг зурагт засах	зассан.
2	Ерөнхий тайлбарт ханын өргийн зуурмагийн маркийг блок, тоосгоор нь ялгах, Тоосгоны зуурмагийн маркийг зөв өгөх	зассан.
3	Суурь суух буурь хөрс нь овойлт үүсгэх тул суурийн ажлыг хэдийд хийх, өвөл өнжих нөхцөлд ямар арга хэмжээ авах талаар тайлбарт тусгах	тайлбарт тусгасан.
4	Баганын сууриас ханын гаргалгаа арматур гаргасан нь ойлгомжгүй байна. Огтлол үзүүлэх	огтлол 4-4-д үзүүлсэн.
5	Хамар ханын суурийг арматурчлах	армаутурчилсан.
6	Суурийн байгуулалтад дулааны оролтын нүхний хэмжээг тавих	тавьсан.
7	Баганан суурийн нүх ухаад хөрс нь суларсан хэсэгт тамбурын суурийг -1,75 түвшинд суулгах нь буруу шийдэл тул засах	зассан.
8	Баганан суурийн хамгийн бага шаталгаа нь 300мм-ээс эхэлнэ. 250мм-ээр өгснийг засах Суурийн улны торны арматурын алхамыг жигд өгөх Баганын суурийн зурагт хаяавчны бүтээцлэл үзүүлэх шаардлагагүй тул хасах	зассан.
9	Сувгийн ханын зургийг өмнө үзсэн халуун усны барилгынхтай адил засах, дулааны оролтын доод түвшин огтлол 2-2-д үзүүлсэнтэй тохирохгүй байна.	ЗАССАН.
10	Ялуу ханын тор гэсэн мөртөө зөвхөн ялууны байгуулалт байна. Ханын торны хэсэглэл деталийг зурагт үзүүлж, зургийг шаардлагын түвшинд хийж өгөх	ЗАССАН.
11	1-р давхрын хучилтын зурагт 2,58м ба 3,88м консоль хучилт хийсэн юм шиг харагдаж байна. Энэ хэсэгт ямар шийдэлтэйн бэ Ер нь каркас, тоосго 2 холилдсон бол буруу гэж үзэж байна. Ба зураг байхгүй тул ханын торны зургаас харахад шийдэл буруу байна.	зассан.
12	Хэрвээ энэ зураг нь холболтын зураг бол булангийн хүснэгтэд бичиж өгөх, Мөн 2 дахь инженерийн шалгалт хийсэн хүн гарын үсгээ зурж баталгаажуулсан байх шаардлагатай.	ЗАССАН.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 2-33 ..... /Н.Эрдэнэсүрэн/

..... оны ..... сарын ..... өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /Ц.Цэрэнчимэд/

2019 оны 09 сарын 18 өдөр

MONGOLIA CONSULTING ENGINEER ERDENESUREN Namjiltseren 01

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР **/Барилга бүтээц:/**
240 суудалтай соёлын төв

2019 оны 09 сарын 16 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	240 суудалтай соёлын төв
2	Объектын байршил, хүчин чадал	Дундговь аймаг, Цагаандэлгэр сум, 1-р баг
3	Зураг төслийн байгууллага	"Өлзий-Иш" ХХК
4	Зургийн шифр	ӨИ-19-19
5	Хуудасны тоо	30
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоос/		
1	7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	
2	7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Барилга нь тэнхлэгээрээ 27х27м-ийн хэмжээтэй 2 зоорьгүй 2 давхар т/б каркасан барилга болно. Инженер Ц.Цэрэнчимэд Шалгасан Д.Ганчимэг
3	7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт;	БИХ-ын Жоншт-Уул ХХК-д 2013 онд боловсруулсан инженер геологийн дүгнэлтээр суурь суух буурь хөрс нь шавранцараар чигжигдсэн хайрган хөрс байна. ГХ-7 балл
4	7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал;	
5	7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	
6	7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
7	7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх;	
8	7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуухь төлөвлөлтийн оновчтой шийдэл;	
9	7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
10	7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	
11	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	

Дүгнэлт бичсэн
Эксперт № 2-33 Н.Эрдэнэсүрэн /...../

MONGOLIA CONSULTING ENGINEER ERDENESUREN Namjiltseren 01-292

2019 оны 09 сарын 16 өдөр

Д/д	Утга	Тайлбар
11	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Барилгын төсөвт өртгийг "Өлзий - Иш" ХХК-д боловсруулсан ӨИ-19-19 шифртэй ажлын зураг төслийг үндэслэн Барилга, цахилгаан, сантехникийн ажлын суурь нормыг мөрдлөг болгон Ажилчны цагийн тарифт цалинг ЗТБХБС-ын 2009 оны 263-р тушаал, тээврийн нэг тн/км-ийн тарифийг ЗТАЖС-ын 2008 оны 136-р тушаал, машин механизмын машин цагийн үнийг ЗТБХБС-ын 2012 оны 18-р тушаалуудаар батлагдсан тарифийг тус тус үндэслэн тооцоолсон байна. Материалын үнийг БХБС-ын 2014 оны 46-р тушаалаар баталсан "Барилгын материал бүтээц эдлэлийн үнийн лавлах, болон зах зээлийн дундаж ханшаар тооцсон байна. Нэмэгдэл дайвар зардлуудыг ЗТБХБС-ын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан "Барилгын төсөв зохиох дүрэм" БНбД81-94-12, БНбД81-95-12-ийг тус тус баримтлан Estimatprpro программаар Тэргүүлэх төсөвчин Д.Ганчимэг тооцоолсон байна. Нийт төсөвт өртгийг **1 250 615 033** төгрөгөөр тооцоолсоныг хянаж баталгаажуулав.
Дүгнэлт бичсэн Эксперт № 16-13	Л.Оюун /...../ 2019 оны 09 сарын 20 өдөр	